

ҮАБЗ-ийн огсон vvргийн дагуу “Афганистаны сургамж” хэлэлцvvлгийг ҮАБЗ-ийн харьяа Стратеги судалгааны хvрээлэн, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэн, Үндэсний Тагнуулын Академийн харьяа Аюулгvй байдал судлалын хvрээлэн, Монголын Дипломатын академи 2021 оны 10 дугаар сарын 06-нд зохион байгуулна. Үvнтэй холбогдуулан БХЭШХ-ээс салбарын хvрээнд “Афганистанд явагдсан байлдааны ажиллагааны туршлага, сургамж” сэдэвт нээлттэй хэлэлцvvлгийг 2021 оны 9 дvгээр сарын 15-ны одор зохи он байгууллаа. Бvс нутгийн тодийгvй олон улсын тавцанд аюулгvй байдлын олон талт асуудлыг хондож байгаа оноодрийн Афганистаны нохцол байдал дэлхий нийтийн анхаарлын товд байна. Афганистанд явагдсан Эвслийн цэргийн ажиллагаанд Монгол Улсын ЗХ-ний бvрэлдэхvvн 2003-2021 онд 18-н жилийн хугацаанд vvрэг гvйцэтгэсэн байна.

“Афганистаны vндэсний армийг хогжvvлэх хотолбор”-ийн хvрээнд vvрэг гvйцэтгэсэн Артиллерийн сургалтын ходолгоонт багийн толоолол; “Аюулгvй байдлыг хангах олон улсын хvчин” ажиллагаанд vvрэг гvйцэтгэсэн Нисдэг тэрэгний техникийн засвар vйлчилгээний сургалтын бvлгийн толоолол; “Аюулгvй байдалд дэмжлэг vзvvлэх олон улсын хvчин” болон “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд цэргийн аюулгvй байдал, хамгаалалтын vvргийг гvйцэтгэсэн цэргийн багуудын толооллvvд оорсдийн цэргийн багийн vйл ажиллагааны онцлог, туршлага, сургамжийн санал бодлоо илэрхийллээ.